

Унгарын билог пайзтай төстэй болох нь

Доктор /PhD/ Обрушански Борбала (Унгар)

Унгар улсын эртний түүхэнд хаадуудын хэрэглэж байсан маш өвөрмөц сонирхолтой зүйл бол билог. Мажарын ханлигт нь уг зүйлийг голдуу XI-XIII зууны үед шүүхийн хэрэгт ашигладаг байжээ. Түүний үүсэл гарлыг мажарын судлаач нар одоо хүртэл тодорхойлж чадаагүй байна. Тэд билогийг зөвхөн гадна шинжээр ерөнхийдөө баруун европынхтой адилтган үзсэн байна. Зарим судлаач билогийг Бизантаас үүсэл гаралтай гэжээ. Харин уг зүйлийн үүсэл гарал өөр газраас үүдэлтэй.

Энэхүү билог бол Мажарын хааны хууль цааз, сурвалж бичигт XI зууны II хагасаас тэмдэглэгдсэн байна. Ласло, Калман хэмээх хоёр мажар хаадууд нь билог хэрэглэдэг журмыг хууль цаазандаа нарийвчлан тэмдэглэсэн байна. Тэдний гаргасан зарим хуулинд билогтай холбогдох зүйлүүдийг дурьджээ.

Археологич нар одоо хүртэл хааны ба шашны хоёр янзын хэд хэдэн билогийг малтан олж, гурвыг нь XI зууны сүүлийн хагаст ашиглаж байсныг тогтоожээ. Андраш хааны (1046-1060) үеийн төстэй хоёр билог, түүнийг залгамжлагч Шаламоны (1068-1074) үеийн бас нэг билогийг олсон боловч харин тэр нь үрэгдэж үгүй болсон. Нөгөө билогийн тухайд зөвхөн музейд зураг нь хадгалагдан үлджээ. XII зуун үеэс хааны болон шашны билог илүү тод мэдэгдэж байна. Тэдгээрийг ерөнхийдөө хүрэл, зэсээр хийсэн байна. Зарим эрдэмтдийн үзэж байгаагаар модоор хийсэн билог ч байсан. Бидний олж мэдсэн билогийн хэв маяг нь дугуй хэлбэртэй, 6 см диаметртэй, дээд хэсэгтээ оосортой, хүзүүндээ зүүдэг байжээ. Хааны билогийн нүүрэн талд хааны хөрөг, шашныхад уг сүмийн сахиусыг дүрсэлсэн байна.¹

Билогийг Мажарын ханлигт эрт үеэс хэрэглэж байжээ. Тэр үед бичиг үсгийн мэдлэг хомс байсан учраас хөдөөгийн засаг захиргааны үүргийг хаан болон шадар хүмүүс ам дамжуулан хэрэгжүүлж байжээ. Тэгэхдээ улсын хэргийг тусгай зөвшөөрөгдсөн бэлэг тэмдгээр баталгаажуулан гүйцэтгэж байсан. Уг тэмдгийг хөдөөний хүмүүс мэддэг учраас хааны төлөөлөгч саадгүй ажиллаж байжээ. Ийм тэмдгийн тогтолцоог бэхжүүлэхэд хэд хэдэн үе шаардлагатай байсан болов уу. Карпатын сав газарт суурьшсан Мажарууд өмнө байсан эх нутгаасаа уг зүйлийг уламжлан авчирсан бололтой.

Мажарын билогийн угсаа гарлыг нэрнээс нь мэдэж болно. Билог уг нь түрэг гаралтай, энэ нь монголын бэлгэ хэмээх үгтэй төстэй утгатай.² Тэр үгийг эртний түрэг овгууд харьцангуй их хэрэглэж байсан, одоогийн Евразийн турк хэлэнд олон янзаар бичиж байна.³

XIX зууны эцсээс билогтай холбогдолтой нарийн судалгаа хийж байснаа харин сүүлийн хэдэн арван жилийн турш уг судалгаа орхигджээ. Билог зүүдэг хүн мажараар "билгош"⁴-ийн үүрэг гүйцэтгэх эрхийг хаанаасаа шууд авдаг байсан. Тэд нар хөдөө нутагт улсын анхан шатны шүүгчид байсан.

Мажар эрдэмтдийн судалгаанаас үзэхэд мажарын хаад билогийг орон нутгийн шүүх засаглалд хэрэглэж байсан: хаан өөрийн итгэмжит шадар хүндээ билог өгөөд үүнийг хөдөө нутагт үзүүлж, шүүхийн үйл ажиллагаа явуулдаг байв. Харин хааны нөгөө итгэмжит төлөөлөгчид өмнө нь ямар үүрэгтэй байсан нь одоо хүртэл тодорхой биш. Дорно дахины жишгээр хааны элч байсан болов уу.

¹ Korai torteneti lexikon. p. 103.

² G. Kara: Majar hel deh mongoltoi tocootei ugsin uchir. In: Mongolica. Vol.11.(32), 2001. pp. 54-61.

³ Dcferfer, 1963. 96. Clauson, 1972. p. 340.

⁴ Билогтай гэсэн утгатай.

Анхны мэдэгдэж буй билог XI зууны II хагасаас олдсон. Харин зарим мажар судлаач нарын үзэж байгаагаар билогийг анхны христос шашинт мажар хаан хэрэглэж байсан бололтой.⁵

Мажар Ласло, Калман хаадын хууль зарлигийг үзвэл ноёдууд шууд хааны шүүхэд хандах эрхтэй болсон байна. Билогош нь хөдөөний чөлөөт эрхтэй хүмүүсийн шүүгч хэвээр үлдсэн. Тэд нар зөвхөн өөрийн харьяалах газарт ажиллах эрхтэй байсан юм. Энэ нь бас хааны хуулинд тодорхой тэмдэглэгдсэн бөлгөө.⁶ XI зууны II хагаст мажарын нийгмийн байгуулалд томоохон өөрчлөлт гарч, чөлөөт эрхтэй хүмүүс хааны болон том ноёны харъяанд оржээ. Хөдөө нутагт хааны төвлөрсөн засаг захиргааны нөлөө бага зэрэг буурсан. Мөн тэр үед христос шашны байгууллага тусгай эрх мэдэлтэй болсон байна. Хөдөөд хааны засаг захиргааны төлөөлөгч бас тусгай эрхийг аваад, тэр нь уг нутгийн шүүхчийн үүрэг гүйцэтгэж байжээ. Ийм нөхцлийг хааны хууль цаазанд тусгаад, өөрсдийн шүүхийн төлөөлөгчийн буюу билогошийн үүргийг хасч, тодорхой газар нутаг, иргэдийн харъяатыг зөвшөөрсөн. Яваандаа тэдний эрх мэдлээ хэрэгжүүлэхэд хааны хөдөөгийн төлөөлөгч болон лам нар саад хийх болсон учраас мажарын хаад хүртэл хүлээн зөвшөөрчээ.⁷

Мажарын хааны засаг захиргаа XII зуунаас суларч, түүнтэй хамт билогошийн ажил ч багассан байна. Тэр үеэс ганцаараа биш, хааны нутгийн захирагчтай хамт шүүхийн үйл ажиллагаа явуулна гэж сурвалж бичигт тэмдэглэжээ.⁸ Билогош нар дээр дурьдсан үеэс голдуу гэмт хэрэг дээр ажиллаж байсан байна. Яваандаа ганцаараа биш, хааны хөдөөгийн засаг захиргааны төлөөлөгчтэй хамтран хэрэг шийтгэх болжээ.

XIII зууны эхэн хагаст бичигдсэн "Varadi Regestrum"-д аймаг бүр 1-2 билогоштай байсныг тэмдэглэсэн.⁹ Мажарын хаант улсын хамгийн чухал үндсэн хууль цаазанд 1222 онд билогош хөдөөгийн засаг даргатай хамт гэмт хэргийг шийдэх эрхтэй байсан тухай тэмдэглэжээ.¹⁰ Билогошийн байгууллага 1240 оноос аймгийн засаг захиргааны харъяанд бараг байхаа болиод, зөвхөн алсын жижигхэн тосгоны анхан шатны шүүхэд үлджээ. Зарим мажар тосгонд билогийг XVIII зууны үе хүртэл ч хэрэглэж байсан аж. Тэгэхдээ билог ч хэрэглэдэг байсан, бас "баарца" гэдэг билогтай төстэй зүйлийг ч ашигладаг байжээ.¹¹

Мажарын түүхч нар билог нь хааны зүүдэг төмөр тамганаас гаралтай гэж үзэж байсан. Түүний хэлбэр, бичээсийн загвар баруун Европынхтай төстэй боловч, Мажар улсаас гадна хаана ч ийм аргаар тамга ашигладаггүй байсан байна. Зарим түүхч билог Бизантаас гаралтай гэж үзээд, харин үүнийг ч билог шиг ашиглаж чадаагүй юм. Билог хэрэглэдэг улс Мажар улсаас гадна Европын хаана ч байхгүй, харин түүнтэй хөрш улсууд заримдаа мажараас билог хэрэглэхийг сурсан аж. Мажартай төстэй зүйл хэрэглэдэг улсууд зүүн тийшээ, нүүдэлчин улсуудад мэдэгдэж буй.

Мажар овгууд эрт үеэс Төв Азид Хүннү нартай хамт амьдарч тэдэнтэй хамт ирсэн гэх мажарын домог бий. Домгоос гадна мажарчуудын нийгмийн байгуулал, зан үйл, ардын уламжлалт ёс заншил нь мөн нүүдэлчин улсуудтай холбогдоно. Мажарын тэргүүлэх овгийн ахлагч нар бас нүүдэлчдийн аргаар улс байгуулсан байна.¹²

Миний бодлоор нүүдэлчдийн аргаар үүсгэн байгуулсан улсад мөн тэр маягийн улс төрийн хэрэгсэл, зүйлийг хэрэглэж байсан байж болох юм. Харин Мажарын хаадууд гаднын жишгээр Баруун Европын зарим зүйлийг ч авч ашигладаг байсан байх.

⁵ Kumorovitz Bernat, 1993. p. 17. , Gyorffy Gyorgy, 1984. p. 184.

⁶ Мажарын Ласло хааны III-р хууль. 1-р зүйл.

⁷ Мажарын Ласло хааны III-р хууль. 10-р зүйл.

⁸ Калман хааны 1-р хууль. 3-р зүйл.

⁹ In: Corpus Juris Hungarici. Varadi Regestrum.

¹⁰ Алтан була гэдэг мажарын анхны үндсэн хууль. 5-р зүйл.

¹¹ In: Hajnik Imre: A magyar birosagi szervezet es perjog az Arpad-hazi es a Vegyes hazi kiralyok alatt. Budapest, 1899. p. 54.

¹² Anonymus: Gesta Hungarorum. p. 5-6. Bp. 1977.

Билогтай хэв маяг, хэрэглэх аргын хувьд яг таарах тийм хэрэгсэл Төв Азийн олон улсуудад байгаа. Энэ тухай Хүннүд анх удаа тэмдэглэгджээ. Монголын бэлгэ, гэрэгэ болон пайз нь Хүннүгийн эзэнт улсын үед анх үүссэн байна.¹³

Х. Нямбуугийн номонд тэмдэглэснээр Хүннүгийн пайз нь үнэт чулуу шигтгэсэн хар чулуун суурьтай байсан ба түүний дээд хэсгээр нь хүзүүндээ зүүж явдаг байжээ.¹⁴ Хэмжээ нь 5-10 см, хэв маяг нь дугуй болон дөрвөлжин хэлбэртэй байсан бололтой. Хэлбэр маяг нь мажарын билогтай төстэй юм. Үүнийг бариулан элч зарах явдал нь нэлээд боловсронгуй байжээ. Хятадын сурвалж бичгүүдэд Хүннү элч нар барууны орнуудад явахдаа билогтай төстэй зүйлийг хэрэглэсэн гэжээ. Чоу Чан шу гэдэг сурвалж бичигт Сяньби улсын элч нар тамгийг хүзүүнд зүүдэг байсан, түүнийг тодорхой хэмжээгээр хэрэглэдэг байсан гэжээ.¹⁵ Харин энэ талаарх анхны археологийн дурсгал бол хятадын Тан улсын албан хэрэгтэй холбоотой баримт сэлтийн дотроос олдсон юм. Пайз ч тэр үед анх удаа олдсон байна. Зарим судлаач нарын бодлоор пайз нь нүүдэлчин маягийн улсаас Умард Хятадад дэлгэрсэн байна.

Мажаруудтай дээр үеэс нягт холбоотой хазаруудын нэг чухал цол “бэлгэчи” байсан. Уг цолын тэмдэг бол яг Мажарын билог мон.¹⁶

Х зууны үед үүсэн байгуулагдсан Кидан улсын талаарх сурвалж бичгүүдэд энэ талаар тодорхой бичигдэн үлдсэн байна. Зарим эрдэмтдийн бодлоор пайз гэдэг үг нь кидан хэлнээс гаралтай. Зарим пайзан дээр “угтуул”, “яаралтай”, “зарлигаар довтлон морилох” гэсэн кидан бичигтэй, мөнгөн пайз, модон пайз, урт пайз, загасан пайз зэрэг олон янзын пайз хэрэглэж байжээ.¹⁷ Үүний дараа XIII зууны эхэн үеэс мандсан Монголын эзэнт гүрний үед пайз гэрэгэ олгох явдал улам өргөжиж, Монголын их хаад болон тэдний хөвгүүд олон янзын пайз хэрэглэж байжээ. Монголын төр ёсонд албан тамга хэрэглэхээс гадна гэрч бичээс бүхий тэмдэг (пайз) олгож байжээ. Түүнийг эртний монгол хэлээр “гэрэгэ” гэдэг. Мөн тийм бичигтэй хөшөөг гэрэлт хөшөө гэх ба хэлэлцэн тохиролцож бичгээр үйлдсэн үйлдлийг гэрээ гэнэ. Ингээд гэрэгэ гэдэг нь хожим пайз гэдэг үгээр солигджээ. Пайз нь бэлгэ тэмдэг гэсэн утгатай үг болно. Эрт цагт улсын хаан, том ноёдоос олгосон эрх бүхий бичигт пайзтай албаны хүн, элч төлөөлөгчдийг саадгүй өнгөрүүлэн, унаа хүнсээр хангах ёстой байжээ. Пайзан дээр: “Мөнх тэнгэрийн хүчинд, хаан нэр хутагтай болтугай. Хэн үл бишрэх алдах үхэх” гэсэн бичээс байсан аж. Тэр үеийн пайзын жишээ гэвэл: Барсын толгойтой алтан пайз: түүн дээр “Тэнгэрээс заяасан Чингис хааны зарлиг, хэргийг үзэмжээр явуулваас зохимой” гэсэн бичигтэй. Жирийн алтан пайз: дээр нь “Тэнгэрээс заяасан Чингис хааны зарлиг, яаравчилтугай” гэсэн бичигтэй. Мөнгөн пайз дээрхтэй адил бичигтэй байсан. Барс тэргүүт гэрэгэ алтан пайз, дээд талдаа сувдтай, доод талдаа хэвтээ барсын дүрстэй алтан пайз зэрэг болно. Ийнхүү Монголын их гүрний үед Юан улсын цагт пайз олгох байгууллага тусгайлан байгуулагдаж, “Алтан тэмдэг”, “Шар алтан тэмдэг, мөнгөн тэмдэг”, “Мөнгөн үсэгт дуут тэмдэг”, “Мөнгөн хөх тэмдэг”, “Гэрэлтэй сувдат барс тэмдэг”, “Уйгур үсгийн барс тэмдэг” зэрэг олон төрлийн пайз байжээ. Эдгээр пайзыг олгох нарийн журамтай байсан. Жишээбэл: Буман цэрэг захирагчид доод талдаа арслан, дээд талдаа нар, сарны дүрстэй алтан пайз, түмтийн ноёнд арслан толгойт алтан пайз, мянгатын ноёнд алт, алтан шармал пайз, муж захирагчид алтан пайз, зарим ноёдод шонхортой пайз зэргийг олгож байжээ.

Зарим алт, мөнгөөр хийсэн зүйлийг нь археологич нар олсон. Монгол улсаар аялсан Европын элч нар замын тэмдэглэлдээ пайзны тухай нарийвчлан тайлбарласан байна. Тэд нарын тэмдэглэснээр бол пайз, гэрэгэ мод, мөнгө, алт, хагас үнэт чулуугаар

¹³ In: H. Nyambuu, 1992. p. 70.

¹⁴ In: H. Nyambuu, 1992. p. 70.

¹⁵ Hou-Han-shu. In: Bichurin, 1950. p. 151.

¹⁶ Peter B. Golden, 1980. p. 166.

¹⁷ Liao-si. p. 213.

хийдэг байжээ. Эдгээрт бичигдсэн зарлиг тушаалыг хүлээн авагч хүмүүст үзүүлснээр тэд түүнд бичигдсэн тушаалыг үг дуугүй биелүүлэх ёстой байв.

Хадгалагдан үлдсэн найзуудаас үзвэл, найзны хэлбэр нь уртавтар болон дугуй хэлбэртэй байдаг байжээ. Дээд үзүүртээ нүхтэй учраас элч нь хүзүүндээ зүүх боломжтой. Найз нь Монголын эзэнт гүрний үед жинхэнэ эрч хүчээ олсон байна. Их хаадүүд найз гэрэгэг авч яваа элчийн эдлэх эрх, үүргийг тодорхой зааж огч байв. Найз гэрэгэгтэй элчийг зарах эрх нь зөвхөн их хаан, түүний гэр бүлийнхэн болон засаг захиргааны удирдагчдад л байсан байна. Улсын элч нар нь найзыг үзүүлснээр буурчийн газарт үнэ төлбөргүй үйлчлүүлэн, гол мөрнийг үнэгүй гатлан гарах болон хаант төрийн албан газруудаар чөлөөтэй орох эрхтэй байжээ.

Бичиг үсэг дэлгэрсний дараа найз гэрэгэг чухал үүртээ алдан, баримт бичигтэй хамт хэрэглэгдэж байгаад сүүлдээ огт хэрэглэгдэхээ больсон. Билэг болон найз гэрэгэг бичгийн соёл дэлгэрэхээс өмнө Унгар болон Монгол улсад голлон хэрэглэж байжээ.

Ашигласан номууд

1. Homan Balint- Szekfu Gyula: Magyar tortenet I. Budapest, 1935.
2. Jakubovich Emil: I. Endre torvenybeidezo ercbilloga. Turul, 47. 1933.pp.56-74.
3. Kubinyi András: Isten baranyal abrazolo torvenybeidezo pecset (billog). Folia Archaeologica Hungariae. 34.1984.pp.139-159.
4. Н. Nyambuу: Hundehijn deed hiу mongolion turin yoson. Цндурхаан, 1992.
5. G. Sukhbaatar: Mongolin ertnii tuuh sudlat. II-r boti. Sjanbi. Ulaanbaatar, 2001.
6. G. Sukhbaatar: Mongol nirun улс. (330-555)Ulaanbaatar, 1992.
7. Louis Ligeti: Le tabghatch, un dialecte de la langue sien-pi.pp.265-309. In: Mongolian Studies. Budapest, 1970.
8. Lovag Zsuzsa: I. Andras idezobilloganak masodik peldanya. Archaeologiai Ertesito 117. 1990. pp.189-201.
9. J.K. Fairbank-S.Y.Teng: On the transmission of Ch'ing documents. In: HJAS, 1939. pp.12-46.
10. Hajnik Imre: A magyar birosagi szervezet es perjog az Arpad hazi es a Vegyes hazi kiralyok alatt. Budapest, 1899.
11. Dzsogderin Bor: Mongolin улс торин гадаад бодлого, дипломатин уландзслалтин зарим асуудал. Ulaanbaatar, 1988.
12. Corpus Juris Hungarici. CD Budapest, 2000.
13. G. Kara: Majar hel deli mongoltoi tocootei ugsin uchir. In: Mongolica. Vol.11.(32), 2001. pp. 54-61.
14. Korai magyar torteneli lexikon. (9-14. szazad). Foszerkeszto: Kristo Gyula. Budapest, 1994.
15. Peter B. Golden: Khazar Studies I-II. Budapest, 1980.
16. A magyarok elodeirol es a honfoglalasrol. Szerkesztette: Gyorffy Gyurgy. Budapest, 1986.
17. H. Perlee: Mongol tmnii garlig tamgaar haidzs szudla'n. Ulaanbaatar, 1975.
18. Stein Aurel: The Ancient Khotan. I-II. Oxford, 1907.
19. Magyar Neprajzi Lexikon. I. Foszerkeszto: Ortutay Gyula. Bp, 1980.
20. Magyar etimologiai szotar. I. Irtá: Gombocz Zoltan as Melich Janos. Budapest, 1914-1930.
21. Kumorovitz L. Bernat: A magyar pecselhasznalat tortenete a kozepkorban. Budapest, 1993.
22. N.J. Bichurin: Szobranie szvedenenij a narodah . obitabsih v Szrednyej Azii v drevnije vremena I. Moszkva-Leningrad, 1950.
23. Sadao Aoyama: Study of the Communication Systems of the Tang and Sung China and the Development of their Topographies and maps. Tokyo, 1963.

Summary

The Hungarian billog and its similarity with the Mongolian paize

In the ancient Hungarian history there was an unique object, name is billog, which was used in the justice practice in the Hungarian Kingdom from the XI-XIIIth century. The orgin of this object is not clear among the Hungarian researchers until now. They tried to explain its usage on the Western European samples, some of them tried to erected from Byzatine Empire. But they investigate this object only formal similarity but not saw its using method. If we are looking at the origin of the word billog, we can find that is has a Altai origin. There is a similar word as belge in Turkish and Mongolian language as well. Beside it, the using method of the Hungarian billog shows its Inner Asian origin. There from the Hun period there was such a object which was used in diplomacy. In the Mongolian period the name of this object became paize or gereg. It can be said that the Hungarian tribes had brought billog from the ancient Inner Asian mother country.